

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

БАТЛАВ.
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР



**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН САНХҮҮЖИЛТИЙН
ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР (2022-2023 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ)-ИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан, Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хорооны 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 102 дугаар захирамжийг үндэслэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-т Сангийн сайд Б.Жавхлан 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө) нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт заасан гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хуулийн тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-ийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд хөтөлбөр хэрэгжсэнээр Азийн хөгжлийн банктэй хамтран Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлага бүхий төслүүдийг хөнгөлөлттэй зээлийн нөхцөлүүдээр хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Эдгээр төслүүдэд Монгол Улсын эдийн засгийн хүндрэлийн үед тулгамдаж буй асуудлууд болох эмзэг бүлгүүдийн орлого буурсан, боловсролын хүртээмж зэрэг нийгэм эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх зорилготой төсөл болон бодлогын зээлүүд, мөн Монгол Улсын хөгжлийн зорилтууд болон "Алсын хараа 2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан зорилтуудын хүрээнд хэрэгжих төслүүд Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (2022-2023 оны зээлийн төлөвлөгөө)-т багтсан ба үүнд хилийн үйлчилгээг сайжруулах, хилийн нэгдсэн системийг бий болгох, Монгол Улс эрчим хүчний хувьд бие даасан болон эрчим хүчний системийн уян хатан байдлыг нэмэх болон бүс нутгийн хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.